

АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ОРЧНЫ ӨӨРЧЛӨЛТ: ЭРСДЭЛ, СОРИЛТУУД

Олон улсын аюулгүй байдлын орчны өөрчлөлт, геополитикийн шинэ сорилтууд дахь Монгол Улс

Пүрэвдоржийн Батжаргал

Доктор (Ph.D), төвийн дарга, batjargal@iss.gov.mn
Монгол Улс, Улаанбаатар, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн
Стратеги судалгааны хүрээлэн

Хураангуй

Олон улсын аюулгүй байдлын орчны өөрчлөлт, чиг хандлага нь нөлөө бүхий хүчний төвүүдийн геополитикийн өрсөлдөөн болон ашиг сонирхлын сөргөлдөөнөө хэрхэн зохицуулахаас ихээхэн шалтгаалах боловч дунд хугацаанд дэлхий даяараа улс төр, эдийн засгийн хямрал, эрсдэл, сорилттой нүүр тулж, энэ нь жижиг, дунд улсуудад илүү хүнд тусаж болзошгүй байна.

Олон улсын харилцаан дахь улс төрийн нөлөө, цэргийн болон эдийн засгийн чадавхаараа давамгайлсан том гүрнүүд өөрсдийн геополитикийн ашиг сонирхлыг хамгаалах, тулган хүлээлгэхийн тулд цэрэг-улс төр, эдийн засгийн дарамт шахалтыг технологийн давуу байдалтай хослуулж, гибрид ажиллагаа явуулах замаар улс орнуудыг богино хугацаанд хямралд оруулж, дэлхийн тогтвортой байдалд шууд болон дам хэлбэрээр нөлөөлж байна.


Дээр дурдсан нөхцөл байдалтай холбоотойгоор манай улсын үндэсний аюулгүй байдлын гадаад орчинд зарчмын гэж болох өөрчлөлтүүд сүүлийн жилүүдэд гарч байна. Юуны түрүүнд умард хөрш ОХУ дайны байдалд, Ойрх Дорнодод дайн дэгдсэн зэрэг үйл явц олон улсын эдийн засгийн харилцаанд томоохон сорилтыг бий болгосноор бидэнд шууд болон дам байдлаар нөлөөлж байна.

Эрчимтэй хувьсан өөрчлөгдөж буй аюулгүй байдлын шинэ орчинд хөгжиж буй улс орнуудад тулгарч буй геополитикийн нийтлэг эрсдэл, сорилт түүний дотор Монгол Улсын аюулгүй байдалд тулгарч буй энэ төрлийн аюул, эрсдэлийн шинжилгээг хийж, үнэлэх, эрсдэл багатай даван туулах боломж, чадварыг Монгол Улсын онцлогт тохирсон байдлаар тодорхойлох шаардлагатай байна.

Түлхүүр үгс: Аюулгүй байдлын гадаад орчин, геополитикийн чиг хандлага, том гүрэн, эрсдэл

Нэг. Олон улсын аюулгүй байдлын орчны өөрчлөлт

“Дэлхийн Эдийн засгийн форум”-аас олон улсын байгууллага, улс орнуудын засгийн газар, бизнес, академик болон иргэний нийгмийн шинжээчдийн санал, дүгнэлтийг нэгтгэн жил бүр гаргадаг “Дэлхийн эрсдэлийн илтгэл-2026”-д дэлхий дахиныг “хадан хавцлын эрмэг дээр тэнцвэрээ олж ядаж буй” төлөвөөр төсөөлж



дүгнэсэн (The Global Risks Report 2026, 2026) явдал өнөөдрийн үнэнд дүйцэхүйц юм. Учир нь нөлөөний бүсээ хадгалах, тэлэхийг чармайх том гүрнүүдийн геополитикийн уламжлалт сөргөлдөөн байгалийн баялаг, геостратегийн ач холбогдолтой бүс нутагт хяналтаа тогтоохын төлөөх орон зайн ашиг сонирхлын давхцалаас үүдэн хурцдаж байна. Үүнтэй холбоотойгоор олон улсын аюулгүй байдлын тогтолцоонд сөргөөр нөлөөлөх үйл явдал бүс нутгуудад өрнөж, нэгэнт “элэгдсэн” дэг журам бүрмөсөн нурж, том хямралд хүргэж болзошгүй шилжилтийн үе өрнөж байна.

Харилцан шалтгаалцал, даяаршил, дижитал үйл явц нийгмийн бүхий л хүрээг хамарч, гадаад, дотоод орчин маш хурдацтай өөрчлөгдөж, ирээдүйн төлөв байдлыг урьдчилан төсөөлөх боломж тун бүрхэг болсон нь өнөөгийн олон улсын харилцааны үндсэн шинж болов (Д.Уламбаяр, 2026).

Уламжлалт бус шинэ тутам илэрч буй кибер орчин, когнитив дайн, хиймэл оюун зэргээс үүдэлтэй эрсдэлт хүчин зүйлс олон улсын тогтвортой байдлыг ганхуулах өөр нэг сорилт болж байна. Уламжлалт цэргийн мөргөлдөөнөөс ялгаатай нь эдгээр хүчин зүйлээр дамжих аюул, эрсдэл дэлхийн улсуудын технологийн хөгжлийн ялгаатай, эмзэг байдлыг ашигласан, харилцан холбогдсон системүүдээр дамжин хил хязгааргүйгээр, урьд өмнө байгаагүй хурдтайгаар тархах боломжтойг дэлхий нийтэд таниулж байна. Мөн чухал ашигт малтмал, газрын ховор элементийн асуудал геополитиктой нягт холбогдсоноор улс орнууд хоёр болон олон талт харилцаандаа хөнддөг нэг гол чиглэл болоод байна. Чухал ашигт малтмал, газрын ховор элементийг эзэмших, ханган нийлүүлэх сүлжээнд давуу талтай байх нь үндэсний аюулгүй байдал, аж үйлдвэрлэлийн бодлого, цэрэг зэвсэг, технологийн давамгайллыг өөртөө бий болгох боломжийг олгох боллоо. Энэ нь олон улсын аюулгүй байдлын орчныг тогтворгүй болгохын зэрэгцээ урьдчилан таамаглахад төвөгтэй сөргөлдөөн, тэмцэл бүс нутгуудад хурдацтай зэрэгцэн өрнөж байна.

Дэлхийн дэг журам, олон улсын харилцааны түвшинд шилжилтийн үеийн томоохон өөрчлөлт өрнөж буй гэдэгтэй аюулгүй байдал судлаачид санал нэгдэж байна. Шилжилтийн гэх энэ үе хэдий хугацаанд үргэлжилж (магадгүй 2030-аад он хүртэл), ямар цар хүрээг хамарч, ямар үр дагавар авч ирэхийг төсөөлөхөд бэрх юм. Учир нь шинжлэх ухаан технологийн үсрэнгүй хөгжил олон улсын харилцаа, аюулгүй байдалд цаашид улам бүр нөлөөлөх эрин үе нэгэнт эхэлсэн.

Дэлхийн I, II дайны гол шалтгаан нь дэлхийн газар нутаг, нөлөөний хүрээг дахин хуваарилах явдалд оршиж байв. Олон улсын аюулгүй байдлын орчинд өрнөж буй өнөөгийн цагийн байдал дэлхийн I болон II дайны өмнөх үеийн геополитикийн сөргөлдөөн, талцалтай зарим талаар төстэй байгаа явдал нийгмийн хөгжлийн

спираль зүй тогтлыг давтаж буй мэт авч улам бүр урвуу хэв шинжтэй буюу улам илүү аюул эрсдэлийг дагуулах вий гэх болгоомжлол төрүүлж байна.

Олон улсын хамтын ажиллагааны хамгийн чухал хүчин зүйл нь олон улсын эрх зүйн хэм хэмжээнд дэлхийн улс орнуудын тогтвортой байдлыг хангах, геополитикийн орчинд урьдчилан таамаглаж болохуйц нөхцөл байдлыг урт хугацаанд хадгалах явдал бөгөөд харамсалтай нь энэ зарчим өөрөө тулгамдсан асуудал болоод байна.

Дэлхий өнөөдөр эрчимтэй хямрал, зөрчилдөөн бүхий тэдгээрийг улс төрийн аргаар бус, хүчээр шийдвэрлэх сэдэл давамгайлсан цаг үед байна. Олон улсын аюулгүй байдлын орчны өөрчлөлт юуны түрүүнд дараах байдлаар илэрч байна. Үүнд:

- Дэлхийн II дайнд ялсан их гүрнүүд “Ялтын гэрээ”-гээр тогтоосон дэг журам, хүчний хуваарилалт бүрэн эвдэгдсэн;
- НҮБ үндсэндээ эрх зүйн чадамжгүй институц болсон. Орон зайг нь нөхөх амбицийг агуулсан шинэ санал, санаачилгуудыг том гүрнүүд гаргах болсон;
- Олон улсын аюулгүй байдлын чиг хандлага “дүрэмд суурилсан” дэг журамт үеэс том гүрнүүдийн хоорондын харилцаанаас хамаарах тогтворгүй байдал руу шилжсэн;
- Геостратегийн ач холбогдолтой, байгалийн арвин их баялагтай газар нутагт хяналтаа тогтоох зорилготой өргөн хүрээний, системтэй ажиллагаа гибрид хэлбэрээр явагдах болсон;
- Том гүрнүүдийн геополитикийн өрсөлдөөн болон олон улсын аюулгүй байдлын төлөв хандлага жижиг, дунд улсад аюулгүй байдлаа хангах бодлого, стратегия тодорхойлоход нөлөөлөх гол хүчин зүйл болж буй;
- Улс орнууд геополитикийн дагуу дахин хуваагдах, аюулгүй байдлын тогтолцооны шинэ блокууд бүрэлдэж болзошгүй нөхцөл де-факто үүссэн;
- Дэвшилтэт технологи, чухал ашигт малтмал, эрчим хүчний ханган нийлүүлэлтийн сүлжээ том гүрнүүдийн өрсөлдөөний шинэ талбар болсон;
- Хүмүүнлэгийн болон дүрвэгсдийн хямрал бодитойгоор нүүрлэж эхэлсэн, цаашид байгалийн гамшиг, цаг уурын өөрчлөлтөөс шалтгаалсан “экологийн дүрвэгсэд” гэсэн шинэ сорилт тулгарахад ойрхон байгаа зэргийг дурдаж болно.

Геополитикийн том тоглогчдын өрсөлдөөн АНУ, Европ болон Ойрх Дорнод гэсэн газарзүйн үндсэн гурван хэсэгт илүүтэй төвлөрч байсан бол цаашид дэлхийн бөмбөрцгийн баруун хагас, Африк тив, Арктик төдийгүй сансрын орон зай геополитикийн тэмцлийн шинэ талбар болох нь тодорхой байна.

Украины дайн, Ираны дайны шалтгаан болон эдгээртэй холбоотойгоор олон улсын харилцаа, аюулгүй байдлын орчинд гарсан өөрчлөлтүүд дэлхийн дэг журмын нурултаас үүдэлтэй геополитикийн сөргөлдөөний хурцилрэл болж байна. Тухайлбал: Венесуэлд явуулсан Америкийн цэргийн тусгай ажиллагаа, Д.Трампын “тарифын

дайн”, Гренландыг худалдаж авах болон Канадыг Америкт нэгтгэх бодлого дунд, жижиг улс орнуудад цаашид тулгарах геополитикийн эрсдэл, сорилтын жишээ юм. Үүнээс олон улсын харилцаа, аюулгүй байдалд дэлхийд нөлөө бүхий улс төрчдийн гаргах шийдвэр нөлөөлж ирсэн түүх хэвээр байгааг харж болно. Энэхүү бусдыг улс төр, эдийн засгийн нөлөөлөлдөө байлгах ашиг сонирхол давамгайлж байсан том гүрнүүдийн геополитик өөрчлөгдөж, тусгаар тогтносон улс орныг эзлэн авах эсвэл өөрийн вассал улс болгох гэсэн илт түрэмгий шинж чанартай болж байна. Энэ нь хөгжиж буй жижиг улсуудын аюулгүй байдал дэлхийн геополитикийг тодорхойлогч гэгддэг улсуудын ашиг сонирхлоос ихээхэн хамааралтай хэвээр байгааг нотлон харуулж байна.

Хоёр. Геополитикийн шинэ сорилтууд дахь Монгол Улс

Дэлхийн геополитик, олон улсын харилцаанд шилжилтийн үеийн томоохон өөрчлөлт өрнөж буй сөргөлдөөнт энэ цаг үед ОХУ, БНХАУ, АНУ-ын “стратегийн гурвалжин” доторх хоёр талын харилцаа хамтын ажиллагаа, ашиг сонирхол, харилцааны аливаа зөрчилдөөн манай улсын аюулгүй байдлын гадаад орчинд нөлөөлж ирсэн төдийгүй цаашид онцгой ач холбогдолтой болно. Учир нь Монгол Улс олон улсын харилцааны түвшинд жижиг улсын ангилалд багтах төдийгүй аюулгүй байдлын орчны өөрчлөлтөд эмзэг хэвээр байна.

Хүйтэн дайны дараах нэг туйлт тогтолцоонд зонхилж байсан АНУ-ын манлайлал суларсны зэрэгцээ БНХАУ-ын өсөлт, ОХУ-ын геополитикийн ашиг сонирхол идэвхэжсэнээр олон төвт тогтолцоонд шилжих хандлага эрчимжиж байна. Энэ нь олон улсын харилцаанд оролцох дунд болон жижиг улсуудын боломжийг өргөжүүлэх эерэг талтай боловч нөгөө талаас том гүрнүүдийн ашиг сонирхлын зөрчил, нөлөөллийн өрсөлдөөн ширүүсэхийн хэрээр аюулгүй байдлын орчин илүү тодорхойгүй, ээдрээтэй болж байна. Үүнтэй зэрэгцэн олон улсын хамтын ажиллагааны институцүүдийн, тэр дундаа НҮБ-ын нөлөө харьцангуй сулрах хандлага ажиглагдаж, зөрчил, сөргөлдөөн “хэвийн үзэгдэл” болох шинж илэрч байгаа нь жижиг, дунд улсуудад шинэ төрлийн эрсдэл үүсгэж байна. Ийм нөхцөлд жижиг, хөгжиж буй улсууд, түүний дотор Монгол Улсын аюулгүй байдал том гүрнүүдийн ашиг сонирхлын огтлолцлоос хамаарах нөхцөл нэмэгдэнэ.

Трамп 2.0 засаг захиргаа Үндэсний аюулгүй байдлын стратеги (National Security Strategy)-ийг 2025 оны 12 дугаар сарын 04-ний өдөр олон нийтэд ил болгосон. Сүүлийн 30 гаруй жилийн туршид дэлхийн геополитикийн чиг хандлагыг тодорхойлж ирсэн АНУ-ын энэхүү баримт бичиг олон улсын харилцаа, дэлхийн аюулгүй байдлын орчинд өрнөх үйл явдлын дунд хугацааны дүр зургийг тодорхойлох чиглэл болдог гэдгээрээ анхаарлын төвд байдаг. (П.Батжаргал, 2025) АНУ-ын ҮАБ-ын шинэ стратегийг ОХУ, БНХАУ харьцангуй прагматик, боломжийг эрэлхийлсэн байдлаар хүлээн авч байгаа нь дэлхийн геополитикийн тодорхойлогч том гүрнүүдийн харилцаа дунд хугацаанд тэнцвэртэй байх болов уу гэсэн найдлагыг төрүүлж байна.

Монгол Улсын аюулгүй байдлын гадаад орчин ОХУ, БНХАУ-тай харилцах бидний бодлогоос болон хоёр хөрш гүрний хоорондын харилцаанаас шууд хамааралтай байж ирсэн явдал түүхэн цаг үед тохиолдсон эрсдэл, сорилт, бэрхшээлээс харагддаг. Түүхээс харахад энэ хоёр улсын харилцаа эерэг байх нь Монгол Улсад болон бүс нутагт нааштай нөлөөтэй байх хандлагатай байдаг. Монгол Улсын хувьд энэ харилцаа хэт ойртох нь мөн эрсдэлтэй байж болно. Нөгөө талаас, харилцааны энэ түвшин ОХУ, БНХАУ-ыг Монгол Улстай харилцах бодлого, үзүүлэх нөлөөний хувьд бие биеэсээ болгоомжлох, тодорхой хязгаарт барьж байх нөхцөл үүсгэх давуу талтай.

ОХУ, БНХАУ-ын хоорондын харилцаа дунд хугацаа (2026-2030 он)-нд өөрчлөлт гарахгүй, одоогийн түвшинд хэвээр байна. Учир нь Украины дайнаас ОХУ эдийн засгийн хувьд хүндхэн гарч ирэх нь тодорхой тул энэ хугацаанд улс төр, эдийн засгийн гол түшиг тулгуур нь БНХАУ хэвээр байх нь тодорхой юм. Мөн олон улсын харилцааны шилжилтийн үед Өрнөдийн эсрэг чиглэсэн Москва, Бээжингийн геополитикийн ашиг сонирхол нийцэж байгаа нь хоёр улсын өнөөгийн харилцаанд эергээр нөлөөлж байна. Энэ нь геополитикийн сэргөлдөөнт өнөө үед Монгол Улсын аюулгүй байдлын гадаад орчинд таатай нөхцөл бүрдүүлж байна. Монгол, Орос, Хятад гурван улсын сайн хөршийн найрсаг харилцаа, 1950-1960 оны үеийнх шиг гурван талт хамтын ажиллагааг хөгжүүлэх таатай нөхцөл, цаг үеийг авчирч болзошгүй ч анхаарах асуудал бий.

Хэрэв геополитикийн сэргөлдөөнт байдлаас үүдэн олон улсын харилцаанд талцал гүнзгийрвэл Монгол Улсын гадаад бодлогод хүчний нөлөөг тэнцвэржүүлэх сорилт тулгарна. Тухайлбал: Зүүн хойд Азийн орон зайд БНХАУ, ОХУ, БНАСАУ гуравласан байдлаар Өрнөдийн эсрэг байр сууриа улам бүр нэгтгэх, нөгөө талаас энэ гурвын эсрэг манай “гуравдагч хөрш” гэгддэг АНУ, Япон улс, БНСУ холбоотны харилцаагаа бэхжүүлэх нь бидэнд сонголт хийх шаардлага, шахалт үүсгэх эрсдэлтэй юм. Хүчний нөлөөг тэнцвэржүүлэх үндсэн нөхцөл нь хараат байдлаас гарах явдал байдаг. Олон улсын харилцаанд хүчний тэнцвэр өөрчлөгдөх, блокт хуваагдах процесс түргэн өрнөхгүй. Иймээс дунд болон урт хугацаанд аль нэг хөршөөс хараат бус байх бодлого, үйл ажиллагаа явуулах нь манай ашиг сонирхолд нийцнэ.

Том гүрнүүдийн бодлого, харилцаанд Монгол Улс нөлөөлөх бодит чадамжгүй бөгөөд тэдгээрийн бодлогоос үүдэлтэй үйл явдал, эрсдэл шууд болон дам байдлаар Монголд хүчтэй нөлөө үзүүлдэг. Эдгээр том гүрний бодлого, ашиг сонирхлын солбицолд улс орнууд тусгаар тогтнож, эсвэл түүхээс арчигдаж байсан нь бий. Манай орны тусгаар тогтнолд ч ОХУ, АНУ-ын оролцоо асар их үүрэг гүйцэтгэж, түүхэндээ бид том гүрнүүдийн нөлөөллийг тэнцвэржүүлэхийг оролдож ирсэн. Эдүгээ Орос-Хятадын харилцаа харьцангуй ойртож, Америк ганцаарчилсан тоглолт хийж байгаа байдал манай “гуравдагч хөрш”-ийн бодлогод сорилт учруулж байна.

Америк, Хятадын хоорондох стратегийн өрсөлдөөн нь дэлхийн II дайнаас хойш бүрэлдэн тогтсон олон улсын худалдааны дэг журамд эрсдэл учруулж

байгааг шинжээчид онцлох болсон. Энэ нь дэлхийн улс орнуудад хүчтэй нөлөө үзүүлж, худалдааны өртөг нэмэгдэх, улс орнууд протекционист бодлого явуулах, улс орнуудын хооронд итгэлцэл сулрах нөлөөг үзүүлж, олон улсын хамтын нийгэмлэгийг хүчгүйдүүлж байна. Мөн өргөн хэрэглээний бараа бүтээгдэхүүнээ гадаад зах зээлээс авдаг, гадаад худалдаанаас эдийн засаг нь үлэмж хамаардаг манай улсад шууд болон дам хэлбэрээр эдийн засгийн хүндрэл, инфляц үүсгэж болзошгүй юм.

Судалгаанаас харахад нийгмийн тогтолцоо, аюулгүй байдлаа хангах арга механизм нь Монгол Улстай ижил төстэй, хөгжиж буй улс орнуудад олон улсын харилцаа, аюулгүй байдлын орчинд гарч буй өөрчлөлттэй холбоотойгоор геополитикийн дараах нийтлэг аюул, эрсдэл тулгарч байна. Үүнд:

- Геостратегийн ашиг сонирхол агуулсан гадны цэргийн түрэмгийлэлд өртөж, улс орныг бүхэлд нь эсвэл нутаг дэвсгэрийнхээ тодорхой хэсгийг алдах;
- Улс төрийн хямралыг өдөөж, засаглалыг сулруулах замаар нөлөөндөө оруулах зорилготой гадны гибрид ажиллагаанд өртөх, улмаар гаднаас улс төр, эдийн засгийн хараат болох;
- Улс төрийн сөрөг хүчин, олон нийтийн эсэргүүцлийн хөдөлгөөн гадны дэмжлэгтэйгээр өнгөт хувьсгал болж хувирах, улмаар зэвсэгт босогчдын зохион байгуулалтад орох, нийгмийн хямрал, иргэний дайнд хүргэх;
- Улс, үндэстний түүхийг зориудаар гуйвуулах замаар тусгаар тогтнол, бүрэн эрхт байдлыг алдагдуулахад чиглэсэн зохион байгуулалттай гибрид ажиллагаанд өртөх;
- Геостратегийн ач холбогдолтой, байгалийн арвин их баялагтай газар нутгийг хэсэгчлэн тасалж авах эсвэл хяналтдаа оруулах зорилготой өргөн хүрээний гибрид ажиллагааны хохирогч, золиос болох;
- Диаспорыг түшиглэсэн салан тусгаарлах бодлогын улмаас үндэсний эв нэгдэл, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдал алдагдах;
- Эдийн засаг, эрчим хүчний эх үүсвэр (газрын тос, байгалийн хий г.м)-ийн хамааралтай байдлаар дамжуулан нөлөөлөх;
- Кибер довтолгоо, мэдээллийн ажиллагаанд өртөх зэрэг аюул, эрсдэл нийтлэг байна.

Геополитикийн сөргөлдөөнт энэ цаг үед Монгол Улсын аюулгүй байдлын гадаад орчин харьцангуй тайван байгаа боловч жижиг, эмзэг улсын хувьд эдгээр аюулаас урьдчилан сэргийлэх хэрэгтэй.

Геополитикийн дээр дурдсан аюул, эрсдэлд өртөх угтвар шалтгааны дийлэнх нь сул засаглал, дотоодын улс төрийн тогтворгүй байдал болж байгааг олон улсын жишээнээс харж болно.

Засаглал сул байвал улс орны үндсэн хуульт байгууллыг сулруулж, сонгуулийн бус замаар төрийн эрхийг авах, нийгмийн тогтолцоог өөрчлөх гэсэн санаархлыг

нэмэгдүүлдэг. Үүнийг гадны нөлөөтэй хэрэгжүүлдэг хувилбарыг “өнгөт хувьсгал” эсвэл “удирдлагатай хаос” гэж нэрлэдэг. Гадны хүчний зүгээс энэ ажиллагааг үндэсний эв нэгдэл алдагдсан болон сул засаглалаас үүдэлтэй нийгмийн бухимдлыг зориуд дэвэргэж, улс төрийн нам, хөдөлгөөнд өөрийн сургаж бэлтгэсэн хүмүүсийг шургуулж санхүүжүүлэх, улмаар иргэдийг өдөөн турхирах хэлбэрээр эхэлж, нийгмийн эмх замбараагүй байдалд хүргэх арга замаар хэрэгжүүлдэг технологи нэгэнт тодорхой болжээ. Үүнд кибер орон зайг өргөн ашиглаж байна. Ийм технологиор явуулдаг гибрид ажиллагааг зарим тохиолдолд түрэмгийлэл гэж үздэггүй. Ийнхүү дотоодын улс төр, эдийн засгийн хямрал, сул засаглалаас үүдэн зарим улс, орон бусдын геополитикийн ашиг сонирхлын золиос болох аюул, эрсдэл оршсоор байна.

Аливаа улс орны аюулгүй байдал бүрэн хангагдсан, ямар ч эрсдэл тулгарахгүй байх тухай ойлголт, хэмжүүр байх боломжгүй. Аюулгүй байдлын онолоор улс орон өөрийн эрх ашгийг хангах аюулгүй байдлын бодлого, түүнийг хэрэгжүүлэх арга замтай байхыг онцолдог. Монгол Улс Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал болон Гадаад бодлогын үзэл баримтлалдаа аюулгүй байдлаа улс төр-дипломатын аргаар хангахыг урьтал болгоно хэмээн заасан нь онолын хувьд аюулгүй байдлын бодлого, түүнийг хэрэгжүүлэх арга замаа тодорхойлсон юм.

Харилцан хамааралтай, даяаршсан, мөн дижитал үйл явцын орчинд жижиг улсын гадаад бодлого илүү прагматик байх ёстой. Монгол Улсын гадаад бодлого энэ хэлбэрээр явж байгаа нь Гадаад бодлогын үзэл баримтлалаа дагаж, улс төр-дипломатын аргаар аюулгүй байдлаа хангахад суурь болж буй юм. Гадаад бодлогод нэгдмэл байдлыг хангаж, залгамж чанарыг хадгалах нь Монгол Улсын өмнө тулгараад буй аливаа эрсдэл, сорилтыг улс төр-дипломатын аргаар бууруулах бодлогыг хэрэгжүүлэхэд нэн чухал болно.

Монгол Улсын гадаад бодлогын тэргүүлэх чиглэл мөнхийн хоёр хөрш ОХУ, БНХАУ-тай харилцах харилцаа мөн боловч тэдний дан болон хавсарсан нөлөө, дарамтад орж, гадна орчноос тусгаарлагдах явдал манай улсын тусгаар тогтнол, бие даасан байдалд учирч болзошгүй хамгийн ойрын буюу хамгийн том сорилт юм. Иймд олон улсын харилцааны шилжилтийн энэ цаг үед Монгол Улс хоёр хөрштэйгөө найрсаг харилцаатай, найдвартай түнш байхын зэрэгцээ “Туравдагч хөрш”-ийн бодлогынхоо хүрээнд тэнцвэржүүлэх бодлогоо тууштай хэрэгжүүлэх нь улам бүр чухал ач холбогдолтой болж байна.

Жижиг улсууд олон улсын тогтолцоонд хүчирхэг гүрнүүдийн дунд оршин тогтнох, бие даасан байдлаа хадгалах гэсэн хоёрдмол сорилттой үргэлж тулгардаг. Том гүрнүүдийн өрсөлдөөн хурцдаж, тэдгээрийн хүчний харьцаа өөрчлөгдөж, олон улсын тогтолцооны тодорхойгүй байдлын үед тэнцвэржүүлэх, аялдан дагалдах, төвийг сахих зэрэг уламжлалт гадаад бодлогын стратегиуд дангаараа хангалтгүй болж, олон талт, харилцан хамаарал бүхий нөхцөл байдалд дан ганц эдгээр стратегийг хэрэгжүүлэх нь улам бүр хялбаргүй болж байна. Ийм нөхцөлд тодорхой бус байдлыг удирдах, эрсдэлийг хязгаарлах, ашиг сонирхлоо хамгаалах

зорилготой уян хатан “hedging” стратеги жижиг улсуудын хувьд прагматик арга болжээ. Тэнцвэржүүлэх стратеги сэргөлдөх, өрсөлдөх зорилготой бол аялдан дагалдах стратеги нь бүрэн хамаарал үүсгэх хандлагатай байдаг. Харин hedging бол энэ хоёрын дунд орших уян хатан, эрсдэлээс сэргийлэх стратеги юм. Иймээс hedging стратеги тодорхойгүй орчинд эрсдэлийн эсрэг даатгалын механизмын үүрэг гүйцэтгэдэг. (Goh.E., 2005) Ийм учраас аливаа улсад нэг талаас хамтын ажиллагаагаар ашиг хүртэх, нөгөө талаас хамгаалалтын арга хэмжээ авч эрсдэлээ хязгаарлах боломж олгодог. Гэвч өнөөгийн олон улсын нөхцөл байдалд hedging стратегийг ашиглах орон зай хязгаарлагдмал болсоор байна. (Б.Алтанхүү, 2025)

Энэ ээдрээтэй үед хүчний тэнцвэрийг барихыг эрмэлзэхээс гадна ашиг сонирхлын тэнцвэрийг барих нь чухал боловч энэ нь бараг боломжгүй юм.

Олон улсын харилцаанд нөлөө бүхий улсуудын геополитикийн өрсөлдөөн хурцадсан өнөөгийн нөхцөлд том гүрнүүдийн ашиг сонирхол, бодлого, стратегитай харшлахгүй байдлаар өөрийн бодлого, үйл ажиллагаагаа хэрэгжүүлэх нь үр дүнтэй юм. Тухайлбал: Монгол Улсын нэг улсын цөмийн зэвсэггүй статус болон НҮБ-ын энхийг дэмжих ажиллагаанд идэвхтэй оролцоо зэрэг гадаад бодлогын санаачилга хоёр хөрш болон “Туравдагч хөрш” орнуудын ашиг сонирхолтой зөрчилдөхгүй тул тэдгээрийн дэмжлэгийг авч, хэрэгжилтийн хувьд үр дүнтэй байх нөхцөлийг бүрдүүлж байгаа юм.

Хэдийгээр сүүлийн жилүүдэд олон улсын аюулгүй байдлын орчинд үүссэн томоохон зөрчил сэргөлдөөнийг шийдвэрлэхэд НҮБ-ын байр суурь сул байгааг шүүмжлэх хандлага байгаа ч олон улсыг хамарсан ийм хэмжээний хамтын ажиллагааны өөр механизм өнөөг хүртэл бий болоогүй байна. (П.Батжаргал, Монгол Улсын аюулгүй байдалд тулгарч буй эрсдэлийн онол, практикт хийсэн шинжилгээ, 2025) Иймээс олон улсын хамтын нийгэмлэгийн үйл ажиллагаанд идэвхтэй оролцох, дэлхий нийтийн болон Монгол Улсын аюулгүй байдал, язгуур ашиг сонирхолд нийцсэн асуудлаар шинэ санал, санаачилга гаргах нь өнөө үед чухал ач холбогдолтой хэвээр байна.

Дүгнэлт

XXI зууны гурав дахь арван жилд дэлхийн аюулгүй байдлын орчин эрчимтэй хувьсан өөрчлөгдөж, уламжлалт хүчний тэнцвэрт тогтолцоо задарч, геополитикийн өрсөлдөөн олон төвт, тодорхойгүй, өндөр эрсдэл бүхий шинэ шатанд шилжээд байна. Дэлхийн Эдийн засгийн форумаас гаргасан “Дэлхийн эрсдэлийн илтгэл-2026”-д онцолсончлон дэлхий “тэнцвэрээ олох гэж буй эмзэг төлөв”-д шилжсэн явдал геополитикийн сэргөлдөөн, технологийн хурдацтай хөгжил, эдийн засгийн тодорхойгүй байдал, нийгмийн эмзэг байдлууд давхардан илэрч буйтай шууд холбоотой байна.

Энэхүү шилжилт зөвхөн том гүрнүүдийн өрсөлдөөний хүрээнд хязгаарлагдахгүй, харин кибер орчин, когнитив дайн, хиймэл оюун,

нийлүүлэлтийн сүлжээ, стратегийн ашигт малтмал зэрэг уламжлалт бус шинэ хэмжээсүүдэд өргөжин тэлж, аюулгүй байдлын ойлголтыг илүү цогц, харилцан хамааралтай шинжтэй болгож байна. Үүний үр дүнд аюул, эрсдэл хил хязгааргүй, өндөр хурдтай тархах боломжтой болж, улс орнуудын эмзэг байдал нэмэгдэн, дэлхийн тогтвортой байдалд урьд өмнө байгаагүй сорилтуудыг бий болгож байна.

Геостратегийн байршил, эдийн засгийн бүтэц, гадаад хамаарлаас шалтгаалан Монгол Улс гадаад орчны өөрчлөлтөд эмзэг боловч тодорхой боломжийг мөн агуулж байна. Тухайлбал: ОХУ, БНХАУ-ын харилцааны тогтвортой байдал, том гүрнүүдийн өрсөлдөөний тодорхой тэнцвэржилт нь Монгол Улсад гадаад бодлогоо уян хатан, прагматик байдлаар хэрэгжүүлэх боломжийг бүрдүүлнэ. Иймд Монгол Улс уламжлалт тэнцвэржүүлэх болон “Туравдагч хөрш”-ийн бодлогоо хадгалахын зэрэгцээ тодорхойгүй орчинд эрсдэлийг удирдах “hedging” стратегийг оновчтой хослуулах шаардлагатай байна. Түүнчлэн кибер орчин, хиймэл оюунд суурилсан мэдээллийн нөлөөлөл, дэд бүтцэд чиглэсэн халдлага зэрэг уламжлалт бус аюул занал нэмэгдэж буй нөхцөлд үндэсний аюулгүй байдлын ойлголтыг өргөтгөн авч үзэх шаардлага үүсэж байна.

Цаашид Монгол Улсын аюулгүй байдлыг хангахад дотоод засаглал, улс төрийн тогтвортой байдлыг бэхжүүлэх, эдийн засгийн бүтцийг төрөлжүүлэх, стратегийн хамаарлыг бууруулах, кибер болон мэдээллийн аюулгүй байдлын чадавхыг нэмэгдүүлэх, олон талт хамтын ажиллагаанд идэвхтэй оролцох, гадаад бодлогын залгамж чанар, нэгдмэл байдлыг хадгалах зэрэг бодлогын чиглэлүүд онцгой ач холбогдолтой байна.

Эцэст нь геополитикийн сөргөлдөөнт, тодорхойгүй орчинд Монгол Улс аюулгүй байдлаа хангахдаа зөвхөн гадаад хүчин зүйлд хариу үйлдэл үзүүлэхээс гадна дотоод чадавх, үндэсний дархлааг бэхжүүлэхэд түлхүү анхаарах шаардлагатай байна. Үндэсний эв нэгдэл, институцийн чадавх, стратегийн уян хатан бодлого нь тусгаар тогтнол, бүрэн эрхт байдлыг хадгалах суурь баталгаа болно хэмээн үзнэ.

Эх сурвалжийн жагсаалт

The Global Risks Report 2026. World economic forum. Retrieved from World economic forum.

Д.Уламбаяр. (2026). News.mn. Retrieved from Дэлхийн дэг журам ба өөрчлөлт: <https://news.mn/r/2854946/>

П.Батжаргал. (2025). АНУ-ын Үндэсний аюулгүй байдлын шинэ стратегийн онцлог. Стратегийн судалгаа 98, 60.

Goh. E.(n.d.). (2005). Meeting the China Challenge. 45.

Б.Алтанхүү. (2025). Жижиг улсын гадаад бодлогын hedging стратеги: Олон улсын аюулгүй байдлын хуваагдмал орчинд хэрэгжих боломж, сорилт. Стратегийн судалгаа 98.

П.Батжаргал. (2025). Монгол Улсын аюулгүй байдалд тулгарч буй эрсдэлийн онол, практикт хийсэн шинжилгээ. Докторын зэрэг горилсон диссертаци. Улаанбаатар, Монгол.

Changes in the International Security Environment: Mongolia in New Geopolitical Challenges

Batjargal Purevdorj

Doctor (Ph.D), Head of Center, batjargal@iss.gov.mn
The Institute for Strategic Studies, National Security Council, Ulaanbaatar, Mongolia

Abstract

The changes and trends in the international security environment will largely depend on how influential power centers manage their geopolitical competition and conflicting interests, but in the medium term, the entire world will face political and economic crises, risks, and challenges, which may hit small and medium powers harder.

In order to protect and enforce their geopolitical interests, major powers with political influence in international relations and military and economic capabilities combine military-political and economic pressure with technological superiority and conduct hybrid operations, which directly and indirectly affect global stability by putting countries in crisis in a short time.

In connection with the above-mentioned situation, fundamental changes have occurred in the external environment of our country's national security in recent years. First of all, our northern neighbor Russia is in the war and the outbreak of war in the Middle East have created major challenges to international economic relations, which have directly and indirectly affected us.

In the rapidly evolving new security environment, it is necessary to analyze and assess the common geopolitical risks and challenges facing some developing countries, including the threats and risks facing Mongolia's security, and to identify the opportunities and capabilities to overcome them with minimal risk in a manner appropriate to Mongolia's specific circumstances.

Keywords: External security environment; geopolitical trends; great power; risk

Received: June 15, 2026 | Accepted: June 29, 2026 | Published online: July 07, 2026



© The Author(s) 2026

<https://creativecommons.org/licenses/by/4.0/>.